



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2016 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А-338

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 5, 6 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А-336/400 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1.5, 2.6 дахь хэсэгт дор дурдсан агуулга бүхий заалтыг тус тус нэмсүгэй.

1/ “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1.5.25 дахь заалт:

“1.5.25. “Тусгай эрсдэлийн сан” гэж “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.11.16-д заасныг;”

2/ “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1.5.26 дахь заалт:

“1.5.26. “Ерөнхий эрсдэлийн сан” гэж “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.11.17-д заасныг;”

3/ “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.6.8 дахь заалт:

“2.6.8. Банк нь эрсдэлээр жигнэсэн активын 1 хувиас ихгүй хэмжээгээр ерөнхий эрсдэлийн сангийн нөөцийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд энэ журмын 2.6.2.-ыг хангахуйц байдлаар оруулан тооцно.”

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1.5.1, 2.7 дахь заалтыг дараах байдлаар тус тус өөрчлөн найруулсугай:

1) “1.5.1. ... Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө” гэдэгт хувьцаат капитал дахь энэ журмын 2.6.4-т заасны дагуу нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд тооцогдсоноос бусад давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн хувьцаа (давуу эрхтэй хувьцаа), дахин үнэлгээний нэмэгдэл, нийгмийн хөгжлийн сан, энэ журмын 2.6.8-д заасан тохируулгыг хийсэн банкны активын ерөнхий эрсдэлийн сан болон 5-аас дээш жилийн хугацаатай хоёрдогч өглөг орно.”;

14 2505

2) “2.7. Эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцохдоо тэнцлийн актив **болон** тэнцлийн гадуур бүртгэлтэй гэрээ, хэлцлийн дагуу бусдын өмнө хүлээж болзошгүй үүргүүдийн “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу тусгай эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн дүнг энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан эрсдэлийн хувь хэмжээгээр үржүүлж, гарах нийлбэр дүнг дараахь байдлаар тохируулна:”.

3.Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 4.6 дахь заалтыг хүчингүй болгосугай.

4.Энэхүү тушаалыг 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг бүх банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

5.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан), Дотоод аудитын газар (Ж.Батхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН